

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА БНХАУ-ЫН БАЙР СУУРЬ

Насан*

НЭГ. ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ОРНУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

АНУ-ын ирээдүй судлаач (футурист) Жон Свит: "XXI зуун бол Азийн зуун, дэлхийн ирээдүй Азид байна" гэж хэлж байлаа. Саяхан Дэлхийн банкнаас гаргасан судалгааг үндэслэн Английн 7 хоног тутмын "Эдийн засагч" сонинд "2020 онд Ази тив Америк, Европыг даван гарч, дэлхийн эдийн засгийн хамгийн том бүс нутаг болно" гэж бичжээ. Түүний дотор Зүүн хойт Ази (ЗХА) бол Ази тивийн хамгийн нөөц бололцоотой, амьдрах хүчин чадалтай бүс нутгийн нэг бөгөөд Азийн сувд гэж нэрлэгддэг. Гэвч, дэлхийн II дайны дараа ЗХА удаан хугацааны турш Хятад, Зөвлөлт, Америк гурван том гүрний гурвалжин харилцааны нөлөөлөлд өртөж, байнгын тогтворгүй түгшүүрт байдалд байсны улмаас бүс нутгийн хамтын ажиллагааны асуудал гэж ярихыг аргагүй байв. Хүйтэн дайн дууссаны дараа, олон улсын байдалд асар их хувирал гарч, энх тайван, хөгжил өнөөгийн дэлхий ертөнцийн гол хандлага болж, олон орны ард түмэн харгис хүч, мөргөлдөөн ба дайныг эсэргүүцэн тэмцэж, энх тайван, тогтвортой байдалын олон улсын орчинг бий болгохыг эрмэлзсээр ирэв. Тухайн улсын болон тус бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх явдал өнөөгийн дэлхий дахины гол урсгал нэгэнт болоод байна. Энэ бүхэн нь олон улсын уур амьсгалд нэн ашигтай юм. ЗХА-ийн орнуудын хөгжил, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ихээхэн боломж байгаа билээ. ЗХА-ийн орнуудын ард түмэн энэхүү түүхэн боломжийг алдахгүй байх нь чухал.

Хятад, Японы мэргэжилтнүүд 90-ээд оны эхнээс эхлэн ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа ба Түмэн голын бүс нутгийг нээж ашиглах, мөн Япон далайн эргэн тойрны эдийн засгийн хамтын ажиллагаа, солилцооны асуудлыг судалсан юм. Эдгээр судалгаа 90-ээд оны эхнээс улам баяжин гүнзгийрч, улмаар олон улсын нийгмийн анхаарлыг татан, ЗХА-ийн улс орнууд хоорондоо аажмаар нэгдсэн ойлголтонд хүрэх болов.

Мөн ЗХА-ийн олон орны засгийн газар ба НҮБ-ын төлөвлөгөө хөгжлийн газрын анхаарал дэмжлэгээр, богинохон хэдэн жилийн дотор буюу 1995 оны 5-р сарын 30-нд Хятад, Орос, Солонгос, БНСУ, Монгол зэрэг 5 орны засгийн газрын төлөөлөгчид, Бээжин хотноо "Түмэн газрын бүс нутгийг нээж ашиглах ажлыг зохицуулах хороог байгуулах тухай хэлэлцээр", "Түмэн голын эдийн засгийн нээлттэй бүс байгуулах ба ЗХА-ийг нээж ашиглах тухай хэлэлцээр", мөн "Түмэн голын эдийн засгийн нээлттэй бүс ба ЗХА-ийн хүрээлэн буй орчны хэм хэмжээг ойлгох санамж бичиг", (меморандум) зэрэг 3 гол баримт бичигт гарын үсэг зурав. Энэ нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа ба Түмэн голын бүс нутгийг нээж ашиглах явдал судалгааны үе шатнаас бодит хамтын ажиллагаа, нээж ашиглах үе шатандаа орсныг харуулж байна.

Сүүлийн хэдэн жилд, олон улсын шинэ уур амьсгалын нөлөөгөөр ЗХА-ийн улсуудын эдийн засаг, худалдааны харилцаа, улс төрийн яриа хэлэлцээ ба цэргийн хамтын ажиллагаа харьцангуй түргэн хөгжиж байна. Тухайлбал:

*БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Ардын засгийн газрын дэргэдэх Зүүн Хойт Ази судлалын хүрээлэнгийн орлогч захирал

1. ХЯТАД, ОРОСЫН ХАРИЛЦАА

а) Эдийн засаг, худалдааны харилцаа. Хятад, Оросын эдийн засаг, худалдааны харилцаанд хэдийгээр зарим нэгэн бэрхшээл байгаа боловч энэ харилцаа хурдан хөгжиж байна. 1994 онд Хятад Оросын худалдааны хэмжээ 5.1 тэрбум америк долларт хүрсний дотор 80% нь хил худалдаа, бүс нутгийн худалдаагаар хэрэгжжээ. Энэ нь Хятад, Оросын худалдаанд хил худалдаа, бүс нутгийн худалдаа чухал байр суурь эзэлж буйг харуулж байна. 1995 онд хоёр орны худалдааны хэмжээ 5.5 тэрбум америк долларт хүрч, 1994 оныхтой харьцуулбал өсөх хандлагатай байна. Хятад Оросын хөрөнгө оруулалтын талаархи хамтын ажиллагаа ихээхэн нөөц бололцоо, боломжтой юм. Иймээс Хятад улс Оросоос иж бүрэн тоног төхөөрөмж авах, барилгын үйлдвэр, аж ахуйн газрыг шинэчлэх, улмаар шинээр эрчим хүч, нүүрс, төмөрлөгийн гэх мэт үйлдвэрийн газрууд байгуулахыг хүсэж байгаа юм. Тухайлбал, Зүүн хойт Хятадад томоохон атомын цахилгаан станц барих гэх мэт. Ерөнхийлөгч Б.Ельцин 1996 оны дөрөвдүгээр сарын сүүлийн хагаст Хятадад айлчлах үед, хоёр тал эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хэлэлцээр, эрчим хүч, сансар судлал, цөмийн энерги, хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбогдсон хэлэлцээр, Оросын Алс Дорнодоос Ази тиврүү нефть, байгалийн хий, цахилгаан эрчим хүч дамжуулах тухай гэрээ зэрэг эдийн засаг, худалдаа, техникийн хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурав. Жишээлбэл: Хоёр тал Оросын Эрхүүгийн байгалийн хийг хамтран нээж ашиглах гэрээ байгуулав. Холбогдох материалыг үндэслэвэл энэхүү байгалийн хийн нөөц нь Азид хамгийн их бөгөөд уг байгалийн хийг ашигалахад 10-20 жил шаардлагатай аж.

б) Улс төрийн талаар. Сүүлийн жилүүдэд, Хятад Оросын удирдагчдын дээд хэмжээний харилцан айлчлал сэргэв. Ерөнхийлөгч Б.Ельцин 1992, 1996 онд хоёр удаа Хятадад, БНХАУ-ын дарга Зянь Земин 1994, 1995 онд хоёр удаа ОХУ-д, 1995 оны зургаадугаар сард Ерөнхий сайд Ли Пен Оросод тус тус айлчлав. Хоёр орны удирдагчдын харилцан айлчлал нь хоёр орны ард түмний харилцан ойлголцол, итгэлцлийг ахиулж, "XXI зуун руу чиглэсэн стратегийн түншлэлийн харилцааг" шинэ үе шатанд гаргав. Ялангуяа 1992 оны арванхоёрдугаар сарын 18-нд гарын үсэг зурсан "ОХУ ба БНХАУ-ын харилцааны үндсийн тухай хамтарсан албан мэдээ" нь Хятад, Оросын харилцааны түүхэнд бодитой, түүхэн ач холбогдолтой чухал баримт бичиг болсон юм. Энэхүү баримт бичиг нь "Одоогоос XXI зуун руу чиглэсэн бүтээн байгуулалтын шинжтэй түншлэлийн харилцааг" бий болгон хөгжүүлэх эрх зүйн үндсийг тавилаа. Дээр дурьдсан албан мэдээнд хоёр орны хоорондын аливаа асуудлыг энх тайвны арга замаар шийдвэрлэх, хоёр тал аливаа нэгэн зэвсэгт хүч хэрэглэх буюу зэвсгийн хүчээр харилцан замалхийлэхээс зайлсхийх, хэн нэгний эсрэг хандсан цэрэг, улс төрийн холбоонд нэгдэхгүй гэдгээ тов тодорхой зарлан тунхагласан юм.

1994 оны есдүгээр сарын 3-нд Орос, Хятад хоёр улс зүүн баруун хэсгийн хилийн хэлэлцээрт гарын үсэг зурав. 1995 оны доллодугаар сард ОХУ-ын парламент, Оросын Дум хийгээд БХАТХ-ын Байнгын Хороо дээрх хэлэлцээрийг соёрхон батлав. Хэлэлцээрийг хүчинтэй болсноос хойш, анх удаа Хятад, Оросын хилийн шугамыг хууль зүйн үндэстэйгээр тогтоов. Хилийн асуудал нь Орос, Хятадын тухайд гэвэл хамгийн эмзэг нарийн асуудал юм. Энэхүү төвөгтэй асуудал эцсийн дүнд шийдэгдсэнээрээ хоёр орны сайн хөршийн найрсаг харилцааны хөгжилд бат бөх үндэс суурь тавиад зогссонгүй, хоёр орны хилийн бүс нутгийн эдийн засаг худалдааны хамтын

ажиллагааг хөгжүүлэхэд ашигтай нөхцөлийг бий болгов.

в) Цэргийн харилцаа. Сүүлийн жилүүдэд, хоёр орны цэргийн салбарын харилцаа мэдэгдэхүйц өсөв. Хоёр орны БХЯ-ны сайд, Жанжин штабын дарга нар удаа дараа харилцан айлчлав. Цэргийн үйлдвэрийн салбар болон зэвсэгт хүчний хоорондын хэлхээ холбоо хийгээд цэргийн технологийн хамтын ажиллагаа ихээхэн гүнзгийрэв. Түүнчлэн хоёр тал атомын бөмбөг ба цөмийн зэвсгийг харилцан үл хэрэглэх тухай хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурсан ба хил орчмын цэргийн хүчний тоог хорогдуулах тухай хэлэлцээ хийж байна. Ялангуяа 1996 оны дөрөвдүгээр сард Орос, Хятад, Казакстан, Тажикстан, Киргизстаны удирдагчид Шанхай хотноо таван орны хилийн бүс нутгийн цэргийн итгэлцлийн арга хэмжээний хэлэлцээрт гарын үсэг зурсан юм.

2. ХЯТАД, ЯПОНЫ ХАРИЛЦАА

Хятад, Японы харилцаа улс төрийн салбарт ч эдийн зэсгийн салбарт ч хангалттай сайн хөгжиж байна. Өрнөдийн том гүрнүүдийн дотроос Япон улс, Хятадтай хамгийн найрсаг сайн харилцаатай байна. Түүнчлэн Япон улс Сянган дараа орох Хятадын хоёрдогч том худалдааны түнш юм. Япон улс одоо Хятад, Оросын нэгэнт хэлэлцэн тогтсон Оросын Эрхүүийн байгалийн хийг хамтран нээж ашиглах төсөлд оролцохоор идэвхитэй ажиллах байна.

3. ОРОС, ЯПОНЫ ХАРИЛЦАА

Өдгөө, Орос улс эдийн засгийн шинэчлэл хийж байгаа бөгөөд эдийн засгаа сэргээхэд нь Японы хөрөнгө оруулалт, технологи чухал хэрэгцээтэй байгаа бол Япон улс Оросын Алс Дорнодын бүс нутгийн байгалийн хий, ашигт малтмалын нөөц баялагийг сонирхож байгаа юм. Иймээс Орос Японы хоёр тал, улс тус бүрийнхээ ашиг сонирхлыг харгалзан хамтын ажиллагаа ахиулахыг хүсэж байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд хоёр орон харицаагаа сайжруулах, хамтын ажиллагаагаа зузаатгахын төлөө нэлээд чармайлт гаргалаа. 1993 онд Оросын ерөнхийлөгч Б.Ельцин Японд айлчилж, хоёр тал "Токиогийн тунхаглал", "эдийн засгийн тунхаглал" гэсэн баримт бичиг гаргав. Тунхаглалд, Орос улс, Зөвлөлт Холбоот Улсын үед Японтой гарын үсэг зурсан бүхий л гэрээг хүчин төгөлдөр хэвээр гэдгийг нотлов. 1994 оны гуравдугаар сард, Японы ГЯЯ-ны сайд асан Хата Цүтоми Оросод айлчлахдаа Оросын зах зээлийн эдийн засгийн шинэчлэлийг дэмжиж байгаагаа илэрхийлж, Япон улс Оростой хамтын ажиллагаагаа цаашид гүнзгийрүүлэн, өргөжүүлэхээ мэдэгдсэн билээ. 1995 оны гуравдугаар сард Оросын ГЯЯ-ны сайд Кириков Японд айлчилж, хоёр тал хоёр орны харилцаа, олон улсын асуудлыг хэлэлцэж, Японы тал 500 мянган ам. долларыг Чечений дүрвэгсдэд тусламж болгон Оросын талд өгөхөөр болов. Мөн онд Оросын БХЯ-ны орлогч сайд хурандаа генерал Громов Японд айлчлахдаа "Хоёр орны түүхэнд анх удаа хоёр талын дээд хэмжээний цэргийн яриа хэлэлцээ" хийжээ. Тэдний хэлэлцсэн гол асуудал нь Оросын арми ба Японы өөрийгөө хамгаалах цэргийн харилцан ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдлын асуудал, хоёр тал цэргийн салбарт харилцан итгэлцэх арга хэмжээний тухай зэрэг болно. 1996 оны гуравдугаар сард Японы ГЯЯ-ны сайд Икэда Оросод айлчилж, хоёр тал 1993 оны "Токиогийн тунхаглал"-ыг хүндэтгэн сахиж, улмаар Оросын БХЯ ба Японы БХЯ-ны хооронд "улс төрийн талаар ойртох" гэрээ хийж, Орос, Японы засгийн газар хоорондын эдийн засаг,

худалдааны хамтын ажиллагааны комисс байгуулав.

Дүгнэн хэлбэл, "Умартын дөрвөн арал"-ын асуудал Орос Японы харилцааны хөгжлийг нэлээд удаашруулж байгаа ч 1994 оны байдлаар Япон, Оросын худалдааны хэмжээ бараг 3.6 тэрбум ам. долларт хүрч, Орос улс Японы Ази дахь хоёр дахь том түнш хэвээр байна.

4. ОРОС, БНСУ-ЫН ХАРИЛЦАА

Сүүлийн жилүүдэд Орос, БНСУ-ын харилцаа Орос Японы харилцаанаас ч илүү хурдан хөгжиж байна. Хоёр тал "ОХУ, БНСУ-ын харилцааны зарчмын гэрээ"-нд болон худалдаа, хөрөнгө оруулалт, шинжлэх ухаан, техник, загасны аж ахуй, агаарын тээвэр, соёлын зэрэг хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зуржээ. 1994 оны зургадугаар сард БНСУ-ын ерөнхий сайд Ким Ён Сан Оросод айлчилж, хоёр тал "ОХУ, БНСУ-ын хамтарсан албан мэдээ"-нд гарын үсэг зурснаас гадна хүрээлэн буй орчинг хамгаалах талаар хамтран ажиллах, далайн аюул осолоос сэргийлэх, нүүдлийн шувуудыг хамгаалах тухай зэрэг хэлэлцээр ба ГЯЯ-ны хэлэлцэн тохирох санамж бичигт (меморандумд) гарын үсэг зуржээ. Хоёр орны цэргийн салбарын солилцоо, хамтын ажиллагаа харьцангуй хурдан хөгжиж байна. ТАСС-ын мэдээлснээр, 1992 оноос 1995 оны тавдугаар сард, Солонгосын жанжин штабын дарга нарын нэгдсэн зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга болон БХЯ-ны сайд нар Орост айлчилсны зэрэгцээ Оросын БХЯ-ны нэгдүгээр орлогч сайд болон БХЯ-ны сайд П.Грачев нар удаа дараа БНСУ-д айлчилжээ. Эдгээр дээд хэмжээний цэргийн удирдагчид харилцан айлчилсаны дүнд хоёр тал БХЯ-ны сайд нар харилцан ойлголцох меморандум цэргийн хамтын ажиллагааны мэдэгдэл зэрэгт гарын үсэг зурсан байна.

Хоёр орны худалдааны харилцаа нэн хурдан хөгжиж байна. 1993 онд хоёр орны худалдааны хэмжээ 1.5 тэрбум ам. доллар байсан бол 1994 онд 2 тэрбум гаруй ам доллар болжээ. Оросын хэвлэлийн мэдээгээр Орос, Солонгосын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлж, 2000 он гэхэд хоёр орны худалдааны хэмжээг 6-7 тэрбум ам. долларт хүргэхээр чармайж байгаа аж.

5. ОРОС, УМАРТ СОЛОНГОСЫН ХАРИЛЦАА

Сүүлийн жилүүдэд янз бүрийн шалтгаанаас Орос, Хойт Солонгосын харилцаа нэлээд хүйтэрлээ. 1995 оноос Оросын БХЯ-ны сайд П.Грачев ардчилсан Солонгост айлчилсанаар хоёр орны харилцаа сайжирч, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа өсөн нэмэгдлээ. 1996 оны дөрөвдүгээр сард Пхеньян хотноо ОХУ, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны комиссын анхдугаар хуралдаан болов. Хуралдааны нээлт дээр, Оросын Засгийн газрын ерөнхий сайдын орлогч, Солонгосын Засаг захиргааны зөвлөлийн Ерөнхий сайдад илгээсэн захидлыг гардуулав. Захидалд онцлон тэмдэглэхдээ: "манай хоёр орон аж үйлдвэр, хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, техникийн зэрэг олон салбарт эдийн засгийн хамтын ажиллагааны баялаг туршлага хуримтлуулсан билээ. Одоогийн зорилт бол хуримтлуулсан туршлагаа ашиглаж, хоёр талын шинэ нөхцөл байдалтай уялдуулан хэрэглэх, хамтын ажиллагааны нөөц бололцоонд тохирсон үйл ажиллагаа явуулах явдал юм" гэжээ. Захидалд цааш дурьдахдаа: "Бүс нутгийн хамтын ажиллагаа бол Орос, Солонгосын харилцааны гол чухал салбар юм. Орос улс, эдийн засгийн талаар Солонгосын түшиж болох түнш нь байх болно. Орос, Солонгосын засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаан одоогийн бэрхшээлийг даван туулж,

манай хоёр орон, хоёр орны ард түмний хамтран ажиллах ашигтай сайхан замыг олж чадна гэдэгт итгэж байна" гэжээ. Оросын ерөнхий сайдын орлогч "Бидний хийсэн хэлэлцээ хоёр орон нэгэнт эдийн засгийн хамтын ажиллагааны тодорхой үндсэн дээр эдийн засаг, худалдааг шинэ чиглэлээр хөгжүүлж болохыг харууллаа" гэв. Солонгосын тал "Бид бие даасан, тэгш эрхтэй, дотоод хэрэгт харилцан үл оролцох зарчмын үндсэн дээр хоёр орны найрамдал, хамтын ажиллагааг чармайн хөгжүүлэх болно" гэж мэдэгджээ.

6. МОНГОЛ УЛСААС ХЯТАД, ОРОС, ЯПОН, СОЛОНГОС, ӨМНӨД СОЛОНГОСТОЙ ТОГТООСОН ХАРИЛЦАА

Монгол Улс, Зүүн хойт Азийн олон оронтой найрамдал, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийг онцлон анхаарч байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол-Хятад, Монгол-Орос, Монгол-Японы хоорондын эдийн засгийн харилцааны хөгжил маш хурдаслаа. 1995 оны I улирал ба 1996 оны I улирлын тоо бүртгэлийн мэдээгээр, монголын нийт импортод Хятад 6.8% ба 9.4%-ийг, Орос 61.6% ба 38.4%, Япон 12.3% ба 21.1%-ийг тус тус эзлэж байна.

Мөн хугацаанд Монголын экспортод Хятад 11.9% ба 12.2%, Орос 14.8% ба 34%, Япон 1.4% ба 3.9% тус тус эзлэж байгаа бөгөөд товчоор хэлбэл, Монголын импорт, экспортын хэмжээ өсөн нэмэгдсээр байна.

Монголын хөрөнгө оруулалтын байдлыг авч үзвэл, 1995 онд Монголд лиценз авсан эхний таван орны хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг тус тусад нь авч үзвэл Орос 143 буюу 36.2%, Хятад 126 буюу 31.8%, Япон 20 буюу 5.1%, Солонгос 9 буюу 2.3%, АНУ 14 буюу 3.5%-ийг эзлэж байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээгээр Орос 27.4%, Хятад 19.5% АНУ 16.5%, Өмнөд Солонгос 7.5%, Япон 3.5%-ийг тус тус эзлэж байна.

Монголын хэвлэлийн мэдээгээр, 1991-1995 он гадаад орнуудаас Монголд 1 тэрбум 173 сая америк долларын тусламж үзүүлсний 40.3% нь буцалтгүй тусламж, 59.75% нь хөнгөлөлттэй зээл юм. Энэ хугацаанд Монголд үзүүлсэн буцалтгүй тусламжийг орон тус бүрээр авч үзвэл: Япон 138 сая 152 мянга 300 ам.доллар, Хятад 3 сая 777 мянган америк доллар болж байна. Мөн хугацаанд монголд өгсөн хөнгөлөлттэй зээлийг улс тус бүрээр авч үзвэл: Япон 82 сая 25 мянган доллар, Орос 38 сая 669 мянган доллар, Хятад 5.5 сая, Солонгос 5.2 сая ам доллар болж байна.

Дээр дурьдсанаас үзэхэд, Монголын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтанд ЗХА-ийн улсууд дийлэнхийг, түүний дотор хөрш хоёр орон, Орос, Хятад тэргүүлэх байр эзлэж байна. Тусламжийн байдлыг авч үзвэл, Японы тусламжийн гол нь Монголд суурь арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Улс төрийн талаар гэвэл Хятад-Монгол, Монгол-Оросын харилцаа хурдан хөгжиж байна. Хятад-Монгол, Монгол-Оросын дээд хэмжээний удирдагчдын харилцан айлчлал харьцангуй сайн өрнөж байна. Хятад-Монгол, Монгол-Оросын хооронд "Монгол Хятадын найрсаг хамтын ажиллагааны гэрээ" ба "Монгол-Оросын найрсаг хамтын ажиллагааны гэрээ"-нд тус тус гарын үсэг зурлаа. Эдгээр гэрээ нь Хятад-Монгол, Монгол-Оросын харилцааны улс төрийн эрх зүйн үндсийг тавилаа.

1996 оны гуравдугаар сард Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэний урилгаар Монголын ерөнхий сайд П.Жасрай БНХАУ-д албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр, хоёр этгээд хоёр талын харилцаа, хамтын санаа тавьж буй бүс нутаг, олон улсын асуудлаар гүн гүнзгий санал солилцож, өргөн хүрээтэй асуудлаар хамтын тохиролцоонд хүрлээ. Хоёр этгээд "энх тайвнаар зэрэгцэн орших таван

зарчим ба 1994 оны Хятад-Монголын найрсаг хамтын ажиллагааны гэрээний үзэл санааг баримталж, хоёр орны сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх нь хоёр орны ард түмний язгуур эрх ашиг, улмаар Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд тустай юм гэдэгт санал нэг байлаа. Мөн хоёр тал Хятадаас Монголд буцалтгүй тусламж үзүүлэх, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр ба хоёр орны боловсрол, соёлын салбарын солилцоо ба хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэг баримт бичигт гарын үсэг зурлаа. Ерөнхий сайд П.Жасрайн айлчлал нь хоёр орны хоорондын харилцан итгэлцлэлийг цаашид гүнзгийрүүлэх, Хятад-Монголын найрсаг харилцааг бататган бэхжүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа.

ХОЁР. ХХІ ЗУУНД ХАНДСАН ЗХА-ИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Өдгөө ЗХА-ийн байдлыг ерөнхийд нь нээштайгаар үнэлж болох ба энх тайван, тогтвортой байдал тус бүс нутгийн гол чиг хандлага болоод байна. ЗХА-ийн орнуудын харилцан ойлголцол, харилцан итгэлцэх явдал тасралтгүй гүнзгийрч, хоёр талын болон олон талын хамтын ажиллагаа зогсолтгүй урагшилж байна. Сүүлийн жилүүдэд ЗХА-ийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа, улс төрийн яриа хэлцэл, цэргийн солилцоо тус бүс нутгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлын механизм бүрэлдэн тогтох анхны үндэс суурь тавигдлаа. Гэвч ЗХА-ийн бүс нутагт урьдын адил улс төр, цэргийн тогтворгүй хүчин зүйлс байсаар байна. Тухайлбал:

1. Түүхээс үлдэж хоцорсон асуудал буюу Япон Оросын Умартын дөрвөн ардын асуудал, Солонгосын хойгийн асуудал, Япон-Өмнөд Солонгосын, Орос-Хятадын газар нутгийн маргаантай асуудал гэх мэт.

2. АНУ-ын хөндлөнгийн оролцоо тус бүс нутгийн тогтворгүй байдлын голлох хүчин зүйлийн нэг болж байна. Одоо АНУ цэргээ Япон, Өмнөд Солонгост байрлуулсаар байгаа ба Солонгосын хойгийн ард түмэн Босни-Герцоговений дайнаас сургамж авах ёстой. Иймээс АНУ тэргүүтэй өрнөдийн орнууд улс төрийн хэм хэмжээний шалтгааныг давхар хэрэгжүүлж, Босни-Герцоговений асуудал өдрөөс өдөрт хурцдаж, дайн шатлан өргөжиж, тэндэхийн ард түмэн дайны гай гамшгийг эдэлж байна.

3. Япон улсын дотоодод оршсоор буй фашизм, милитаризм бол тус бүс нутгийн улс төрийн байдал тогтворгүй байх гол хүчин зүйлийн нэг юм. Японы ард түмэн энхийг эрхэмлэдэг ард түмэн хэдий ч одоо Японд нэгэн сайхан өглөө "Зүүн Азийн цэцэглэл мандлын хамтын их хүрээг" бий болгох хуучин зүүдээ сэргээх гэсэн санаархалтай харгис хүчин байсаар байна. Тэгээд ч ойрын хэдэн жилд Японы улс төрийн бодлого баруун тийш хандаж буй нь улам тод болж байна. Дэлхийн олон орны ард түмэн ялангуяа Зүүн хойт Ази, Ази-Номхон далайн бүс нутгийн ард түмэн нэгдэн нягтрах хэрэгтэй бөгөөд сонор сэрэмжээ алдаж болохгүй. Түүнчлэн дээр дурьдсан хүчин зүйлүүд хувирч өөрчлөгдөх нь энэ бүс нутгийн хамтын ажиллагаа, хөгжил цэцэглэлтэнд шууд нөлөөлөх болно. Энэ нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв, эцсийн эцэст тус бүс нутаг улс төрийн тогтвортой байдлаа удаан хугацаагаар хадгалж чадах эсэхээс хамаарна. Иймээс тус бүс нутагт урт хугацааны улс төрийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд хамтдаа даган сахих аюулгүй байдлын механизмыг бий болгох нь өнөөгийн ЗХА-ийн олон орны өмнө тулгарч буй шинэ асуудал юм.

Одоо, ЗХА-ийн орнууд энэ асуудлыг идэвхитэй судлан шинжилж байна. Жишээлбэл, бүр эрт 1992 онд Оросын ерөнхийлөгч Б.Ельцин БНСУ-д айлчлах үед "ЗХА-ийн олон талт хэлэлцээний механизм бий болгох санал дэвшүүлж байлаа. Япон улс "ЗХА-ийн бүс нутгийн индэр", "Ази, Номхон далайн олон талт аюулгүй байдлын механизм" бий болгох, БНСУ "ЗХА-ийн хэлэлцээний конгресс", "ЗХА-ийн ГЯЯ-ны сайд нарын байнгын хуралдаан" бий болгох зэрэг санал дэвшүүлж байв. Түүнчлэн Хятад, Орос, Япон, Өмнөд, умарт Солонгос зэрэг оронд цэргийн дээд хэмжээний төлөөлөгчид олон удаа харилцан айлчилж, цэргийн хамтын ажиллагаа ба тус бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар хэлэлцэн зөвлөлдлөө. Ялангуяа 1996 оны дөрөвдүгээр сард Орос, Хятад, Казахстан, Тажикстан, Киргизстаны удирдагчид Шанхайд гарын үсэг зурсан таван орны хилийн бүс нутгийн итгэлцлийн арга хэмжээ авах хэлэлцээр нь Төв Азийн аюулгүй байдлын бүтцийг бий болгох ба бүс нутгийн интеграцийн үйл явцыг хурдасгахад ихээхэн нөлөөлсөн төдийгүй ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлын механизмыг бий болгоход идэвхтэй нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Бүс нутгийн аюулгүй байдлын механизмыг ямар зарчмаар бий болгох вэ гэдэг нь маш чухал асуудал юм. Хятад улс "Ази-Номхон далайн аюулгүй байдлын индэр" хурал дээр, Ази-Номхон далайн аюулгүй байдлын механизмыг бий болгох 5 зарчим дэвшүүлсэн юм. Эдгээр 5 зарчим нь:

1. Энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмыг үндэс болгон, бүс нутагт жанжлалыг бий болгохгүй, гадаадын цэргийг байрлуулахгүй, цэргийн бүлэглэл бий болгохгүй байх

2. Улс хоорондын дайн мөргөлдөөнийг энх тайвнаар шийдвэрлэх, тухайн үед нь шийдвэрлэж боломгүй бол... улс орнуудын хоорондын байнгын хэлхээ холбоог дэмжиж байх

3. Цэргийн зэвсэглэлийг батлан хамгаалахад шаардлагатай түвшинд байнга байлгах, Америк, Орос хоёр том цэргийн гүрэн эхэлж зэвсэглэлээ хорогдуулах ёстой, ялангуяа далай, агаарын цэргийн зэвсэглэлээ

4. Цөмийн зэвсэгтэй бүх гүрнүүд цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй ба цөмийн зэвсэггүй оронд хэрэглэх буюу цөмийн зэвсгөөр заналхийлэхгүй байх үүрэг авах ёстой.

6. Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, шинжлэх ухаан техникийн солилцоог улам ахиулах, хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудыг туслан дэмжих

Энэхүү 5 зарчим маш чухал бөгөөд ЗХА-ийн бүс нутгийн аюулгүй байдлын механизмыг бий болгоход бүрэн нийцэх юм. Тус бүс нутагт дээр дурьдсан тогтворгүй байдлын олон хүчин зүйл байгаагийн улмаас аюулгүй байдлын механизм бий болгох нь тийм ч амаргүй бөгөөд тодорхой үе шат, үйл явцыг туулж гарах нь зайлшгүй юм. Энэ үе шат, үйл явцыг хэрэгжүүлэхдээ дараах 3 алхамыг хэрэгжүүлж болох юм. Тухайлбал:

1. "Засгийн газар хоорондын индэр"-ийн механизм бий болгох

2. "Засгийн газар хоорондын бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулах" механизм бий болгох

3. Нөхцөл бүрдсэний дараа, Хятад улсын дэвшүүлсэн дээр дурьдсан 5 зарчмын үндсэн дээр ЗХА-ийн орнууд хамтаараа дагаж мөрдөх эрх зүйн үйлчлэл бүхий олон талт бүс нутгийн аюулгүй байдлын механизмыг аажмаар бий болгох явдал юм.

ЗХА-ийн улс орнууд их, бага гэлгүй цөм адил тэгш эрхтэй. Тус бүс нутгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлын асуудалд цөм эрх тэгш үгээ хэлэх эрхтэй. ЗХА-ийн улсуудын ард түмэн бол ЗХА-ийн

жинхэнэ эзэн, ЗХА-ийн хувь заяа, аюулгүй байдлын асуудлыг бүс нутгийн улсуудын ард түмэн өөрсдөө шийдвэрлэх ёстой, бусад бүс нутгийн аливаа нэг хэт их гүрэн энд хуруу дүрж, хошуу нэмэх учиргүй, улмаар ямар нэгэн шалтаг, арга хэлбэрээр бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудалд хөндлөнгөөс оролцож болохгүй. Хятад, Орос, Япон улс бол энэ бүс нутгийн том гүрэн төдийгүй энх тайван, тогтвортой байдлын үндэс мөн. Иймээс ЗХА-ийн аюулгүй байдлын асуудалд Хятад, Орос, Япон улс чухал харицлага хүлээх ёстой бөгөөд тэд, юуны өмнө, дээр дурьдсан 5 зарчмыг чанд хүндэтгэн сахих ёстой юм. Газар зүйн байрлалын тухайд гэвэл Хятад улс ЗХА-ийн гол цөм нутагт оршдог учраас ЗХА-ийн хөгжил, аюулгүй байдалд улам илүү их хувь нэмэр оруулах учиртай.

Хятад улс дэлхийн цөмийн зэвсэгтэй цөөн гүрний нэг гэдгийг бүгд мэднэ. Гэвч Хятад улс бага хэмжээний цөмийн зэвсгийг судлан бүтээж хөгжүүлэхдээ бусдыг айлган заналхийлэх гээгүй, батлан хамгаалах хэрэгцээ, эерийгээ хамгаалах, улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, ард түмэн ба энх тайван амар тайван амьдралаа хамгаалахын төлөө л байсан юм. Хятад улс цөмийн зэвсгийг бий болгон хөгжүүлэхдээ дэлхийн энх тайвныг хамгаалахын төлөө, цөмийн зэвсгээр айлган сүрдүүлэх, заналхийлэх явдлыг таслан зогсоохын төлөө, цөмийн дайнаас сэргээх, эцсийн эцэст цөмийн зэвсгийг устгахын төлөө байгаа юм.

Түүнчлэн, Хятад улс цөмийн зэвсэгтэй болсон анхны өдрөөсөө эхлэн "Хятад улс ямар ч үед, ямарч байдалд, түрүүлж цөмийн зэвсэг хэрэглэхгүй" гэж ёс төртэй мэдэгдсэн юм. Хятад улс ямар ч нөхцөлд "цөмийн зэвсэггүй улс орон ба бүс нутагт цөмийн зэвсгийг хэрэглэх, түүгээр заналхийлэхгүй" гэдэг үүрэг авсан юм. Хятад улс бол дэлхий дээрхи цорын ганц ийм үүрэг авсан цөмийн зэвсэгтэй улс билээ. Хятад улс жилийн чандад цөмийн зэвсэг байрлуулаагүй, мөн бусад улс оронд цөмийн зэвсгийг хэрэглэх буюу түүгээр айлган заналхийлөөгүй юм. Мөн Хятад улс биеэ даасан эзэн мэдсэн энх тайванч гадаад бодлогыг тууштай баримталж, цөмийн зэвсгийг бүх талаар хориглох, бүрмөсөн устгахыг тууштай зорино. Иймээс өрнөдийн зарим улсуудын тэрээж буй "Хятадын аюул" гэгч огтхон ч үндэслэлгүй юм.

БНХАУ бол энх тайвныг эрхэмлэгч улс, даян дэлхийн энх тайван тогтвортой байдлыг хамгаалах чухал хүчин мөн. Өнгөрсөн жилүүдэд Хятад улс энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр улс гүрнүүдийн хамтын ажиллагаа, найрамдалт харилцааг зузаатгаж, жанжлалдыг сэргүүцэхийн тулд, дэлхийн энх тайвныг сахин хамгаалахад чухал хувь нэмэр оруулсан юм. Түүнчлэн одоо Хятад улс шинэтгэл, нээлттэй бодлогоо хэвээр баримталж, сайн хөршийн найрсаг, энх тайванч гадаад бодлогоо хэрэгжүүлж, улсын дотоод улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн өндөр хурдацтай өсөлтөө хадгалан, улс орныхоо нийт хүчин чадлыг тасралтгүй нэмэгдүүлж, олон улсын байр сууриа байнга дээшлүүлж, олон улсын үйл хэрэгт улам бүр чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Хятадын хүн ам олон, зах зээлийн багтаамж их бөгөөд ЗХА-ийн орнууд ч харилцан нэхэх чадвар ихтэй юм. Иймээс ч Хятад улс хойшид ЗХА-ийн бүс нутгийн улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийн төлөө улам бүр их хувь нэмэр оруулах нь дамжиггүй.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав